



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2012 оны 06 сарын 15 өдөр

Дугаар A/335

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах, тушаалын заалтыг
хүчингүй болгох тухай

Засгийн Газрын 2012 оны 19 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” 416 дугаар тушаалын Жасрай овогтой Сонинбаяр, Бавуудорж овогтой Ганбат нартай холбогдох хэсгийн “Нидерланд Улсын Твенте их сургуулийн магистрантурт 1,5 жилийн” гэснийг “Франц Улсын Найс София Антиполис их сургуулийн магистрантурт 2 жилийн” гэж, 2006 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн “Гадаадад суралцуулах тухай” 303 дугаар тушаалын хавсралтын Бямбажав овогтой Өнөрмаатай холбогдох хэсгийн “магистрантурт 2 жилийн” гэснийг “докторантурт 3 жилийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 14 дүгээр тушаалын Бямбажав овогтой Өнөрмаатай холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

3. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

ДЭД САЙД

Б.УНДАРМАА

